



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/32

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Биеийн тамир спортын газрын "Б" заалны засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "ЭПО" ХХК-тай 241,963,702 /Хоёр зуун дөчин нэгэн сая есөн зуун жаран гурван мянга долоон зуун хоёр/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг төсвийн дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "ЭПО" ХХК-ийн захирал (Ж.Пүжий)-д даалгасугай.

4.Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010611

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 сарын
30 өдрийн 1/13 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	3,941,026	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	3,941,026	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	1,970,513	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн	15,000,000	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
6	Ажил гүйцэтгэх хугацаа	80 хоног	Ү.Бямбасүрэн
7	Гүйцэтгэлийн баталгааны дүн	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь.	Д.Батцогт
	Орон нутгаас авч ажиллах ажилчдын тоо	10 хүн	Н.Батжаргал